

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2019 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа зохион байгуулагдаж, 7 асуудал хэлэлцэж, 2 иргэнийг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж, 2 иргэнд 600000 төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 24 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2019 оны 11 дүгээр сарын 16, 19, 21-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд нийт 59 иргэн бүртгүүлснээс 55 иргэн орж, 7 иргэн тэнцсэн. Шалгалттай холбоотой ямар нэгэн гомдол, санал гараагүй.

Аймаг орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнд өртөх эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, гамшгийг даван туулах чадавхаа бэхжүүлж бэлэн байдлаа хангах хүрээнд 11 дүгээр сарын 18-ны өдөр “Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл”-ийн 3 дугаар хуралдааныг зохион байгуулсан. Тус хуралдаанаар 2020 онд хийх ажлын төлөвлөгөө, шаардлагатай төсөв, хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах санд төвлөрүүлэх талаар хэлэлцэж, зөвлөлийн гишүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа, зорилго, чиглэл, бүтэц зохион байгуулалт, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, чадавхын талаарх сургалтыг зохион байгуулсан.

#### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2019 оны 11 дүгээр сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 4852,4 сая төгрөг төвлөрүүлэхээс, 6089,6 сая төгрөг төвлөрүүлж 125.5 хувьтай байна.

2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлтэй ХК-1, ХХК-296, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27, ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, Төрийн бус байгууллага-89, Шашны байгууллага-5, Сан-10 нийт хуулийн этгээд 593 байна.

Татварын хяналт шалгалтаар нийт 33554,0 мянган төгрөгийн зөрчилд 3355,4 мянган төгрөгийн нөхөн татвар, 1006,6 мянган төгрөгийн торгууль, 671,1 мянган төгрөгийн алданги, нийт 5033,1 мянган төгрөгийн шийтгэл оногдуулсан.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 9092.4 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 6921.7 сая.төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийн 788.7 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс харьяа агентлагуудтайгаа хамтран 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр иргэдэд үйлчлэх өдөрлөг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Статистикийн хэлтсүүд өөрийн үйл ажиллагааны талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, танилцуулга хуудас тараах зэрэг үйлчилгээг давхардсан тоогоор 118 хүнд үзүүлсэн. Мөн Эрдэнэс таван толгой ХК-ны 1072 хувьцааг хоёрдогч зах зээлд гаргах бэлтгэл ажлыг хангах тухай Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс таван толгой” ХК-ны ажлын алба ирж иргэдэд хувьцаа, үнэт цаасны талаар ойлголт өгсөн.

**Статистикийн чиглэлээр:** 2019 оны 10 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгыг бэлтгэж аймгийн болон хэлтсийн цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл хуудсаар 45, цахимаар 150 хэрэглэгчид хүргүүлсэн.

**Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:** Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 10 дугаар сарын шилэн дансны мэдээллийг шалгахад 5 байгууллага хангалтгүй, 77 байгууллага хангалттай үнэлгээ авч хуулийн хэрэгжилт 93.9 хувьтай байна.

Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 29367,3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 4912,1 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 21878,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэж тусгуулахаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

**Нийгмийн даатгалын сангаас олгосон:Тэтгэвэр**

№	Төрөл	2018.11.24		2019.11.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/	
1	Өндөр настан	1629	5850857,3	1748	6556615,9	119
2	Тахир дутуу	312	800672,1	370	942661,9	58
3	Тэжээгчээ алдсан	132	343978,6	131	349135,2	-1
4	Үйлдвэрийн осол	46	242057,6	27	281059,7	-19
	<b>Нийт дүн</b>	<b>2119</b>	<b>7237565,6</b>	<b>2276</b>	<b>8129472,7</b>	<b>157</b>

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж**

№	Төрөл	2018.11.24		2019.11.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	1478	151979,4	1446	187516,1
2	ЖБА тэтгэмж	358	466351,3	354	553669,6
3	Оршуулга	72	72000,0	64	64000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	40	43820,1	11	4777,9
5	Ажилгүйдэл	180	299342,9	198	324045,0
	<b>Нийт дүн</b>	<b>2128</b>	<b>1033493,7</b>	<b>2073</b>	<b>1134008,6</b>

**Сайн дурын даатгал:**

Сайн дурын даатгалын хамрагдал	2018.11.24	2019.11.24
Шинээр	227	267
Мөнгө тушаасан	664	672
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	171580,2	229209,9

**ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр:** 11 дүгээр сарын 8-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн бүх албан хаагчид болон эрх бүхий албан тушаалтнууд, иргэдэд зориулсан сургалт, уулзалтыг зохион байгууллаа. Төрийн албан хаагчдын сургалтанд 150 төрийн албан хаагч хамрагдсан бол иргэдтэй хийх уулзалтанд 50 иргэн оролцсон.

**Архивын ажлын чиглэлээр:**

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 1979-2009 оны 28 хадгаламжийн нэгжийн 2120 заалт бүхий 8701 хүний нэр, 1681 байгууллагын нэр, 3071 газар зүйн нэр, нийт 2260 хуудас баримтыг цахимжууллаа. Архивын баримтаас 23 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлсэн байна.

2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр төрийн байгууллагын архив бичиг хэргийн ажилтнуудад “Албан хэргийн стандарт, өргөдөл гомдол бүртгэх, хүлээн авах арга зүй” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад төрийн байгууллагын 53 бичиг хэргийн ажилтан хамрагдсан.

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан -38
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -57
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 32

- Гэрлэлт бүртгүүлсэн тоо-4
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо-1
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо-2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо-8
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн-39
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо-17

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл -5
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл-33
- Гэрээний бүртгэл-22
- Барьцааны гэрээний бүртгэл -136
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга-2

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл-3
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт-4

**Архивын чиглэлээр:**

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар-26
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-144

Нийт 573 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн байна.

**Цагдаагийн хэлтэс нь:** 2019 оны эхний 10 сарын байдлаар иргэн, хуулийн этгээдээс 585 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 204 буюу 34,8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 381 буюу 65,1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 36 буюу 15 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 59 буюу 18,3 хувиар өсч, нийт хүлээн авсан гомдол мэдээлэл 23-аар буюу 4,1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Улсын хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх ажилд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хамтын ажиллагааг сайжруулах зорилго бүхий "ОЙЛГОЁ-ХҮНДЭЛЬЕ" аяныг зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хөгжих өрхийн 50 иргэнд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль" болон "Гэр бүлийн харилцаа" сэдвээр сургалт зохион байгуулсан.

Шивээ-овоо ХХК, Прокурорын газартай хамтран ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчдын дунд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлье" сэдэвт "Дэвжээ" тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 110 сурагч, 11 багш хамрагдсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын 2, 5 дугаар сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдын 730 эцэг, эх, асран хамгаалагчид "Хүүхэд хамгааллын тухай хууль"-иар болон хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар мэдээлэл хийлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төвтэй хамтран такси үйлчилгээ эрхэлдэг 4 байгууллагын 60 жолоочийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, жолооч тус бүрийг замын хөдөлгөөний дүрмийн түвшин тогтоох шалгалтанд хамруулан, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадварыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн такси үйлчилгээ эрхэлдэг "Сүмбэр хас" ХХК, "Монгол шуудан" ХК, "Чойрын хүлэг" ХХК-ны зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслийн судалгааг гаргаж, жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар сургалт зохион байгуулсан.

“Жим зам” төрийн бус байгууллагатай хамтран, Баянтал сумын 1 дүгээр багийн нутаг босоо тэнхлэгийн Улаанбаатар-Чойр чиглэлийн А0101 авто замын 200 дахь км орчимд осол, аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн модель машин байрлуулсан.

“Зэвсэг-2019” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж галт зэвсгийн нэгдсэн санд давхардан бүртгэгдсэн 5 галт зэвсгийг бүртгэлээс хасуулж, бусад аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс 4 галт зэвсэг хүлээн авч, 3 галт зэвсгийг шилжүүлсэн. Одоогийн байдлаар 189 галт зэвсгээс 183 галт зэвсэг буюу 96,8 хувийг, 3 галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэж 100 хувь нэгдсэн санд оруулсан.

Тооллогын явцад галт зэвсгийн загвар хийц өөрчилсөн, ашиглах боломжгүй байсан 5 галт зэвсгийг хураан авч “Галт зэвсгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-аас хасалт хийсэн.

Галт зэвсгийн тухай хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд галт зэвсгээ хэрхэн бүртгэлжүүлэх талаар зөвлөмж бэлтгэн цахим сүлжээгээр иргэдэд хүргэлээ.

Оюу толгой ХХК, Мобиком корпораци, Цагдаагийн ерөнхий газартай гэрээ байгуулсны дагуу 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өөр орон нутагт хийгдэх замын цагдаагийн постыг орон нутагт татан үйл ажиллагааг нь эхлүүлж, Дорноговь-Говьсүмбэр аймгийг холбосон анхны дундаж хурдыг хэмжих, зөрчил илрүүлэх, дугаар бүртгэх хүчин чадал бүхий хяналтын камерын нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Шүүхийн шинжилгээний албанаас хэргийн газрын үзлэгт 20 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон хэргийн 8, зам тээврийн ослын 9, бусад хэргийн газрын үзлэгт 3 удаа оролцож, Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 650 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Тайлант хугацаанд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 29 удаа хийж дүгнэлт гаргасан. Мөн 8 цогцосны задлан шинжилгээнд оролцсон.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь:** 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар шинээр ирсэн 20 хоригдлыг хүлээн авч 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Хоригдлуудыг нийгэмшүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хугацаанаас өмнө суллагдах хүсэлт гаргасан 31 хоригдолд “Хөдөлмөрийн хууль”, “Халамжийн тухай хууль”-иар сургалт зохион байгуулсан.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хоригдлыг бичиг баримтжуулах буюу иргэний үнэмлэх шинээр болон дахин олгох, иргэний үнэмлэхний хугацаа /25-45 насны/ сунгах зэрэг зөрчилтэй 2 хоригдлыг бичиг баримтжуулсан. Мөн 1 хоригдлын гэрлэлтийн баталгааг Иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлсэн.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** 2019 оны эрсдэлийн үнэлгээг нийт 30 шалгуур үзүүлэлтээр 1127 объектод хийхэд их эрсдэлтэй 141, дунд эрсдэлтэй 471, бага эрсдэлтэй 514 объект үнэлэгдсэн.

Сүмбэр суманд 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй аймгийн нэгдсэн эмнэлэг, 2 дугаар сургууль болон 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгуудын барилга угсралтын талбайд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн. Шалгалтын явцад барилга угсралтын талбайн эмх цэгцийг хангуулж, 5 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 3 аж ахуй нэгж байгууллагад 35 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, барилга угсралтын талбайд тавигдах аюулгүй ажиллагааны дүрэм, шаардлага стандарт хангаж ажиллаагүй 1 аж ахуй нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна.

Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл баталгаажилтгүй, мэдрэхүйн эрхтний үзүүлэлтээр сэжигтэй бүтээгдэхүүний 5 дээжийг хими, нян судлалын лабораторийн

шинжилгээнд хамруулахад 2 эерэг /хар чавга, набор/ сорьц илэрч, 7,4кг 96070 төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн актаар хураан авч Захиргааны орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дээрх бүтээгдэхүүнүүдтэй холбоотой сэрэмжлүүлгийг иргэдэд хүргэж ажилласан.

Аймагт хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгжүүдэд хөгц, мөөгөнцөр зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн болон шинжилгээний дүнг засварласан цайг худалдаалж буй эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтын явцад “Gimex” ХХК-ийн Хөсөг цай, Нутгийн цай ХХК-ийн Шар цай (пакеттай) 30ш, Гүрж ногоон цай болон буталсан (грузия кобулети чай) цайны хугацаа дууссан байхад хуурамч шошго нааж хүнсний худалдаа үйлчилгээнд нийлүүлсэн, худалдан борлуулж байсныг хяналт шалгалтаар илрүүлж, илэрсэн зөрчлийн хүрээнд 3 нэр төрлийн 285100 төгрөгийн үнэ бүхий 90ш цайг улсын байцаагчийн актаар хураан авч, зөрчлийг таслан зогсоох, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцуулахаар харьяа хяналтын байгууллагад шилжүүлж, хяналт шалгалтын мэдээллийг цахим сайтад байршуулж иргэдэд сэрэмжлүүлсэн.

Хүнсний чанар, стандартын болон эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчдын болон аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр ирүүлсэн усны 9, жавельсины 2, гурилан бүтээгдэхүүний 2, хоолны 2, хиамны 1, нийт 16 сорьцод 2-9 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн. Эерэг сорьц илрээгүй байна.

**Онцгой байдлын газар нь:** Хээрийн түймэр, мал амьтны гоц халдварт өвчин, хууль бус ан агнуур, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Эргүүл шалгалтын ажил зохион байгуулах тухай” А/59 дүгээр захирамжийн дагуу 11 дүгээр сарын 9-ний өдөр хээрийн түймэр гарах магадлалтай Баянтал сумын нутаг дэвсгэр, Сүмбэр сумын 5,6 дугаар багийн нутаг дэвсгэрт эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллаа. Эргүүл шалгалтын үеэр 5, 6 дугаар багийн нийт 10 өрхийн 25 иргэнд өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр гарсан тохиолдолд унтраах арга зүйн талаар болон гамшиг аюулт үзэгдэл, хүчтэй цасан болон шороон шуурга, хүн малын гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, хээрийн түймэр, малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч ажиллах талаар заавар зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлэх тараах материал 150 ширхэгийг тараасан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу 11 дүгээр сарын 09-ний өдөр хяналт шалгалтыг 10 байгууллага, аж ахуй нэгжид зохион байгуулахад 45 зөрчил дутагдал илэрсэн ба 10 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, 35 зөрчлийг байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн заавар зөвлөмжийг хүргэж ажиллав.

“Цасан болон шороон шуурга шуурах, хүйтрэх” талаар хөдөөгийн багийн 252 иргэнд “Багц мессеж” үйлчилгээг ашиглан хүргэсэн.

Орон нутгийн сонсгол хэл ярианы бэрхшээлтэй 21 иргэнд гамшиг осол, гал түймрийн сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг багц мессежээр авах болон дугаарын танилцуулгыг хүргэж, гар утасны дугаарыг бүртгэж цаашид багц мессежээр мэдээлэл хүргэх боломжтой болсон.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ,СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Ерөнхий боловсролын сургуульд 2-4 жил ажиллаж буй багш нарт “Орон нутгийн үндсэн сургалт”-ыг зохион байгуулж, хүүхэд хамгааллын бодлого, боловсрол дахь хүүхэд хамгаалал, үнэлгээний журмын үзэл баримтлал, хэрэгжилтэд анхаарах асуудал сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Сургалтад 64 багш хамрагдсан.

Суурь болон бүрэн дунд боловсролын багш нарт сайжруулсан хөтөлбөрийн төлөвлөлт, анхаарах асуудал, Монгол хэлний хичээлээр сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулсан туршлага, Монгол бичгийн хичээлийн шилдэг туршлага, Биеийн тамирын хичээлээр хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжсэн сайн туршлага түгээж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Боловсрол, соёл урлаг, спортын яам, Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран “Бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдлэг чадвар олгох нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 28 багш хамрагдаж, хүүхдийг хүчирхийллээс хэрхэн хамгаалах талаар мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн.

2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Сэтгэлийн боловсрол” сэдвээр сэтгэл судлаач, багш Ким Соны лекц зохион байгуулж, 1,2,5 дугаар сургууль болон 1,2,5,6 дугаар цэцэрлэгийн 120 багш, ажилтан хамрагдлаа.

2019 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр МУБИС-ийн математикийн тэнхимийн эрхлэгч дэд профессор Б.Сандагдорж “Математикийн бодлого бодох аргачлал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Тус сургалтад математикийн 18 багш хамрагдлаа.

**Спортын чиглэлээр:** 2019 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд “Спортын мастер Б.Мөчирөөгийн нэрэмжит шатрын тэмцээн” зохион байгуулагдсан. Тэмцээнд өсвөр болон ахмад насны эрэгтэй, эмэгтэй ангиллаар хурд хүч, оюун ухаанаа сорин 31 тамирчин өрсөлдлөө.

2019 оны 11 дүгээр сарын 09-10-нд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Бага олимп” спортын наадмын Жүдо бөхийн тэмцээн зохион байгуулагдаж, 4 сургуулийн 90 гаруй сурагч, эрэгтэй 9 жин, эмэгтэй 6 жинд хурд хүч авхаалж самбаа сорин өрсөлдсөн.

“Усаар чийрэгжье” аюул өдөрлөгийг 2019 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр усан спорт сургалтын төвд зохион байгуулсан. Тус тэмцээнд өсвөрийн төрөлд 16-17 насны 50 тамирчин, насанд хүрэгчдийн төрөлд 20 гаруй тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Боржигин чуулгын “Өвөл цагийн үзвэрийн нээлт”-ийн арга хэмжээг 2019 оны 11 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж “Хөх толботон” хамтлагийн “Дээдсийн сургаал”, “Сонгодог үдэш”, “Гала” тоглолтуудыг зохион байгуулсан.

**Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын чиглэлээр:** Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг сурталчлан таниулж, эрүүл чийрэг бие бялдрыг цогцлооход иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийг оролцуулан идэвхжүүлэх, орон нутгийн ард иргэдийг аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, зөв дадалтай болгох зорилгоор 2019 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр “Эрүүл бие-саруул ухаан-эрүүл хөдөлгөөн 60” дасгал хөдөлгөөний тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 12 байгууллагаас бүрдсэн нийт 8 багийн 200 гаруй албан хаагч оролцсон.

Орон нутагт манлайлагч залуусыг бэлтгэн тэднээр дамжуулан зөв зан үйлийг залуучуудад төлөвшүүлэх, хувь хүн хэрхэн өөрийн амьдралаа төлөвлөж, өөрийгөө болон гэр бүлээ удирдан манлайлах, илтгэх ур чадварыг нэмэгдүүлэх, багийн нягтралыг сайжруулах, хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгоор онол, практик хосолсон сургалтаар дамжуулан залуучуудыг идэвхжүүлэхэд чиглэсэн “Хувь хүний хөгжил-манлайлал” сэдэвт сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад төрийн байгууллагын 50 залуу албан хаагч хамрагдлаа.

2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, багаар чиглүүлэгч багштай хамтран ажиллах аргад сургах, сурагчдад эрдэм шинжилгээний ажлын ач холбогдлыг таниулах, судалсан сэдвийн хүрээнд оновчтой санал бодлоо илэрхийлж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох чадварыг эзэмшүүлэх зорилгоор “Хүүхэд насны эрдмийн ажил” илтгэлийн уралдааныг зохион байгуулсан.

Уралдаанд Уул уурхайн жишиг сургууль политехникийн коллежийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид оролцсон. Тус илтгэлийн тэмцээнд 14 багийн 56 сурагч оролцож мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө.

"Хүүхдийн хөгжил хамгааллын жишиг сургууль" хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн сурагч, багш, эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг "Гэр бүлийн боловсрол олгох, хэрхэн сайн эцэг эх байх тухай", "Хүүхэдтэй зүй бус харилцахаас урьдчилан сэргийлэх нь" сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Тус сургалтад 200 гаруй багш, эцэг эх, сурагч хамрагдсан.

"Forms for dorms" хөгжлийн хөтөлбөрийн сургалтыг Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны сурагчдад эрүүл зан үйл, дадал хэвшил олгох, амьдрах ухаан болон амьдрах чадварт сургах, тэднийг үе тэнгийнхэндээ манлайлах оролцоог нэмэгдүүлэх, дотуур байранд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Forms for dorms" сэдэвт сургалтыг Дэлхийн Зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Сургалтад Төв аймаг, Дундговь аймгийн 40 сурагч оролцож харилцан бие биеэсээ суралцлаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/350 дугаар захирамжаар сумдын хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор аймгийн "Зөвлөх баг"-ийг байгуулан ажиллаж байна. "Зөвлөх баг"-ийн гишүүд 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Сүмбэр, Шивээговь, Баянтал, Хэнтий аймгийн Дархан, Баянмөнх, Бор-Өндөр сумдын "Хамтарсан баг"-ийн 60 гишүүнд Хамтарсан багийн үйл ажиллагаа болон салбар гишүүдийн үүрэг оролцооны чиглэлээр Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран зохион байгууллаа. Тус сургалтын үеэр Дэлхийн зөн олон улсын байгууллага, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн хэлтэстэй хамтран "Хамтарсан баг"-ийн гишүүдийн хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Эрх зүйн олимпиад"-ыг зохион байгуулсан.

#### Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2018 оны 11 сар	2019 оны 11 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	434	390
Гэрийн төрөлт	0	1
Амьд төрсөн хүүхэд	433	392
Амьгүй төрөлт	1	3
Нас баралт	58	52
Эмнэлгийн нас баралт	9	10
Хоног болоогүй нас баралт	3	3
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	5
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	4682	4096
Амбулаторийн үзлэг	102468	79280
Халдварт өвчин	234	141

Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль"-иар сургалт зохион байгууллаа. Сургалтад 13 эмч, эмийн сангийн ажилтан хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.

"Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр", "Тэмбүүг устгая" үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

Эмгэг судлалын үндэсний төвөөс "Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх нь", "Эмэгтэйчүүдийн эсийн шинжилгээг зөв авах арга барил" сэдэвт сургалт зохион байгууллаа. Сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн эмч, эх баригч, өрх сумын Эрүүл мэндийн төвийн эх баригч, эмч, сувилагч, хавдар бүртгэгч нийт 15 хүн оролцсон.

2019 оны 10 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд “Эрүүл зүрх-Эрүүл хөдөлгөөн-Эрүүл ёс зүй” төслийн хүрээнд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран иргэдэд зүрх судасны нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээ зохион байгууллаа. Үзлэгт нийт 216 иргэн хамрагдсан.

Сонгдо эмнэлгийн зүрх судасны тасгийн эрхлэгч Ц.Намхайдорж аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд “Артерийн даралт бууруулах, зүрхний оношилгоо эмчилгээний арга”, “Зүрхний архаг дутагдлыг оношлох, эмчлэх арга зүй” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон.

2019 оны 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран элэг цөс, нойр булчирхай, эмэгтэйчүүд, цээжний хөндийн мэс засал, хөнгөвчлөх эмчилгээ, эхоны нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. Үзлэгт 689 иргэн хамрагдсан. Тус арга хэмжээний үр дүнд шинээр хортой хавдар 7, хоргүй хавдар 45, хавдрын урьтал өвчин 82, бусад өвчлөл 309, хавдрын сэжигтэй илэрсэн 4 хүн тус тус илэрч 3 дугаар шатны нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлсэн.

2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Хорт хавдрын өвчлөл нас баралтын өнөөгийн байдал”, “Ходоодны хорт хавдрын шалтгаан, эрсдэлт хүчин зүйл, оношилгоо эмчилгээ”, “Элэгний хавдрын эрт илрүүлэг, ЭХО оношлогоо, эмчилгээ”, “Умайн хүзүүний хавдрын шалтгаан, оношилгоо эмчилгээ”, “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Солонгосын Олон Улсын эрүүл мэндийн сан “КОFИH” -ын санхүүгийн болон техникийн туслалцаатайгаар хэрэгжиж буй “Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төсөлд Шивээговь сум сонгогдон алслагдсан малчин, иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, эрт илрүүлэг шинжилгээг зохион байгуулж байна. Төслийн хүрээнд хүн амын дунд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг зохион байгуулж байна. Төслийн үйл ажиллагаанд Шивээговь сумын 1552 иргэнийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулахаас 11 дүгээр сарын 20-ны байдлаар 1333 иргэнийг хамруулж хамралтын хувь 89.7 хувь байна. Программд үзлэгт хамрагдсан 1054 иргэний мэдээллийг оруулж шивэлт 84.4 хувьтай байна.

Үүнд: 0-5 хүртэлх насны хүүхдээс 219 хамрагдахаас 170 хамрагдаж 77,6 хувь

5-17 нас: 364 иргэн хамрагдахаас 364 хамрагдаж 100 хувь

18-39 нас: 587 иргэн хамрагдахаас 418 хамрагдаж 71,2 хувь

40-64 нас: 341 иргэн хамрагдахаас 340 иргэн хамрагдаж 99,7 хувь

65-аас дээш: 41 иргэн хамрагдахаас 41 иргэн хамрагдаж 100 хувь тус тус хамруулаад

байна.

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** 2019 оны 11 дүгээр сарын 19-ний байдлаар нийт 6876 иргэнд 1 871 205 578 төгрөгийг зарцуулсан байна.

№	Үзүүлэлт	2019.01.01-2019.11.19	
		Хүн тоо	Мөнгөн дүн
1	Халамжийн тэтгэвэр	259	436442830
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	286	208592710
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	263	133750530
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, насны	1163	111572475



	хишиг		
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	347	53055090
6	Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	498	69129670
7	Цалинтай ээж	1157	424332050
8	Өрх толгойлсон эхийн тэтгэмж	51	43634670
9	Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	7	13441610
10	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1312	173380000
11	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	127	10250000
12	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	704	86273943
12	Насны хишиг олголт	702	107350000
<b>Нийгмийн халамжийн сангийн дүн</b>		<b>6876</b>	<b>1871205578</b>

Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Хүртээмжтэй ирээдүй” сарын аяныг зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд төрийн үйлчилгээг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх, тэдэнтэй харьцах харилцааны чадварыг эзэмшүүлэх зорилгоор дохионы хэлний анхан шатны сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад төрийн болон төрийн бус байгууллагын 25 албан хаагч хамрагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урласан бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх, бусдад үлгэр дуурайлал болгох зорилгоор оёдол-эсгүүр, эсгий-гар урлалын үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан бөгөөд үзэсгэлэнд 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэн урласан бүтээлээрээ оролцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулж, авьяас, ур чадварыг нь нээн илрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор даам, суугаа волейбол, ширээний шагай, орс таталт, гар барилдаан, хонхот теннис зэрэг 6 төрлөөр спортын тэмцээн зохион байгуулж, 40 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцсон.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 11 өрхийн малчдаас 7 малчныг Өвөр Монголын өөртөө засах орны Авгын хошуу, Зүүн сөнөд хошуу, Эрээн хотын малчидтай уулзуулан мал маллагааны арга ажиллагаа, ноос арьс шир боловсруулах арга зэрэг туршлага солилцох арга хэмжээг 11 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

25 буюу түүнээс дээш ажилтантай 36 аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Аймгийн хэмжээнд 36 аж ахуйн нэгж, байгууллагад 94 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 2018 онд 54 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байсан бол 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 38 байгууллагад 76 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 27 хувиар нэмэгдсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй 9 аж ахуй нэгж байгууллагаас 20377.1 мян.төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.

## **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **Мал, аж ахуйн чиглэлээр:**

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 2018 оны үлдэгдэл өвс 80 тн, тэжээл 26 тн, Сүмбэр сум 73 тн өвс, Баянтал сум 20 тн өвс, 3.5 тн тэжээл, Шивээговь сум 14 тн өвс, сумдын аюулгүй нөөцөд нийт өвс 107 тн, тэжээл 3.5 тн нөөцөлсөн.

Малх отрын бүсэд 2019-2020 оны өвөл, хавар өвөлжиж, хаваржихаар нүүж ирэх 30.0 мян.толгой мал бүхий оторчид болон манай аймгийн нутгаар дамжин зүүн аймгуудад оторлохоор яваа малчдыг орох, дамжин өнгөрөх замын маршрутыг аймгийн Засаг даргын 2019 оны А/373 дугаар захирамжаар тогтоож, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумдаас 89 өрхийн 53262 толгой мал цаг хүндэрвэл Дорноговь, Дундговь Хэнтий, Төв, Дорнод аймгийн зарим сумдад отроор өвөлжих, хаваржих санал ирүүлснээс 42 өрхийн 16843 толгой мал оторт гараад байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан нэгдсэн дүн:

Д/Д	Сумын нэр	Малчдын өвс, тэжээл бэлтгэл /хүснэгт 5-17/	Аймгийн аюулгүйн нөөц бэлтгэл /хүснэгт 6-7*/	Сумын аюулгүйн нөөц бэлтгэл /хүснэгт 6-7/	Худгийн бэлэн байдал /хүснэгт 7-6/	Малын усан хангамж /хүснэгт 7-8/	Малчин өрхийн хашаа бууцны хангамж /хүснэгт 8-7/	Өрхийн өвөлжилтийн бэлтгэл /хүснэгт 9-9/	Өвөлжилтийн бэлтгэл хангасан ерөнхий дүн /хүснэгт 10-ын 1-7-гийн дундаж/
		Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь
	0	1	2	3	4	5	6	7	8
1	Баянтал	26.4		27.0	84.6	100.0	93.2	88.0	69.9
2	Сүмбэр	41.9		74.0	95.4	100.0	100.0	89.0	83.4
3	Шивээговь	43.1		14,0	95.1	100.0	100.0	84.0	72.7
	Аймгийн дүн		291.0						75.3
	<b>Дүн</b>	<b>37.1</b>	<b>291.0</b>	<b>38.3</b>	<b>91.7</b>	<b>100.0</b>	<b>97.7</b>	<b>87.0</b>	<b>106.1</b>

Ноосны урамшуулал олгож эхэлсэнтэй холбогдуулан данс, нэр зөрүүтэй 29 иргэний мэдээллийн зөрүүг засварлаж хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/303 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/372 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвийн 75.0 сая төгрөгийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажил хийгдэж байна. Бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажлын явцад тогтмол хяналт тавьснаар ажлын үр дүнд ахиц гарч байна. **Газар тариалангийн чиглэлээр:** Энэ онд 18 га-д төмс, 18 га-д хүнсний ногоо, 12 га-д тэжээлийн ургамал, 0.2 га-д жимс, жимсгэнэ, нийт 48.2 га талбайд тариалалт хийхээс 17.9 га-д төмс, 18.8 га-д хүнсний ногоо, 12 га-д тэжээлийн ургамал, 0.45 га-д жимс жимсгэнэ тариалж, тариалалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувь байна. Ургац хураалтын ажлын үеэр цаг агаарын хүндрэл гараагүй бөгөөд зүтгэх хүчний 2, бага оврын 1 трактор, 2 тоног төхөөрөмж ажилласан.

Энэ онд нийт 326.6 тн ургац хураан авсан. Ургац хураалтын явцад 19.4 га талбайд техникийн үйлчилгээ үзүүлсэн.

Атрын 60 жилийн ойн хүрээнд Өглөөний мэдээ сонинд “Тал нутгийн атар газар эзэмшигчид” нэртэй нийтлэл хэвлүүлж, атар газар эзэмших их үйлсэд гар бие оролцож, хийж бүтээж явсан ахмадуудаа алдаршуулж, газар тариалангийн талаархи мэдээллийг иргэдэд хүргэсэн.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2019 оны 11 дүгээр сарын үнийн мэдээ**

09 дүгээр сарын сүүлч 11 дүгээр сарын эхээр малчдаас зах зээлд нийлүүлэгдэж буй махны нийлүүлэлт ихсэж байгаа тул зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай, цул/ махны үнэ 500 төгрөгөөр, ямааны мах /ястай/ 500 төгрөгөөр төмс болон зарим, хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-200 төгрөгөөр буурсан бол ургамлын тос 50 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	Ястай	8500	6000	-500
		Цул	10000	10000	-500
2	Хонины мах	Ястай	6500	4500	-
		Цул	9000	8500	-
3	Адууны мах	Ястай	6500	5000	-
		Цул	9500	9000	-
4	Ямааны мах	Ястай	5000	4000	-500
		цул	9000	8500	-
5	Тахианы мах	Гуя	8500	8500	
		мөч	9200	8500	
6	Лууван	монгол	2000	1500	-
		хятад			
7	Төмс	монгол	1000	500	-50
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1200	-300
		хятад			-
9	Чинжүү	монгол			-
		хятад	7000	6800	
10	Манжин	монгол	1200	1200	-50
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	2000	1600	-
		Хятад	1600	1200	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	монгол	3500	3000	-
14	Элсэн чихэр	монгол	2100	1800	-
15	Будаа	Цагаан задгай кг	2500	2000	-100
		Шар слава кг	3100	2900	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	2000	1500	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3000	2950	-
17	Тараг	Задгай	2500	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	800	-
19	Өндөг	ОХУ	450	300	-5
		Монгол	400	250	-15
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1480	1400	-
		Задгай 1-р зэрэг	1100	1080	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан /дээд /	1650	1600	-

		Савласан дээд	1650	1600	-
		Савласан 1-р зэрэг	1300	1200	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1600	1500	-
		А/тариа савхан	1000	900	-

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоотой хамтран “Хэрэглэгчдээ дээдэлсэн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого” сэдэвт сургалт, семинарыг Улаанбаатар хотод 2019 оны 11 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулж, орон нутгийн салбар нийгэмлэгийн тэргүүн, ажилтан 90 төлөөлөгч оролцсон. Энэ сургалт нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг, боловсрол олгох, чанар стандарт, аюулгүй байдлын шаардлага хангасан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хэрэглэгчдэд нийлүүлэх, хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад олон нийт, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, Хэрэглэгч-Төрийн байгууллага- Аж ахуйн нэгжийн гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болж, аймгийн төлөөлөл оролцсон.

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг аймгийн хэмжээнд нийт 32 байгууллага ирүүлэхээс 25 байгууллага хугацаандаа ирүүлээд байна. Үүнээс 20 байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, 5 ААНБайгууллагын менежментийн төлөвлөгөөний тайланг засаж сайжруулан ирүүлэх талаар зөвлөгөө өгөн буцаасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Хандлагаа өөрчилье” багц ажлын хүрээнд орон даяар зохион байгуулж буй “Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн өнгө үзэмжийг сайжруулах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, авто зам дагуух барилгын хур хог хаягдлыг дарж булах, хуучин ахуйн хог хаягдлыг тээвэрлэх ажлыг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын дэмжлэгтэйгээр 3 га талбайн барилгын туурь хог хаягдлыг цэвэрлэсэн.

Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн “Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагатай хамтран 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр “Нийтийн хоол ба аялал жуулчлал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтыг Монгол Улсын Их сургуулийн Аялал жуулчлалын тэнхимийн багш зохион байгуулж, орон нутгийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 12 байгууллагын төлөөлөл хамрагдсан байна.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 11 дүгээр сард 8 хугацааны мэдээг нийт 240 удаа, хөдөө, аж ахуйн ажиглалт зогссон, хөрсний чийгийн ажиглалтыг 1, климат агро дундаж хөдөө аж ахуйн тойм мэдээ болон 10 хоногийн тойм мэдээг нийт 3 удаа, сарын тойм мэдээг 1 удаа тус тус төв станцад дамжуулсан.

11 дүгээр сарын цаг уурын тойм мэдээгээр: 12, 16, 17-ны өдрүүдэд цас орсон. Нийт 0.9 мм тунадастай. Салхи ихэнхи хугацаанд 4-9 м/сек, зарим үед 10-12 м/сек хүрч салхилав. Агаарын дундаж температур 5.6 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь 18-ны шөнө 27,5 градус хүйтэн, хамгийн дулаан нь 02-ны өдөр 12,8 градус дулаан байсан.

11 дүгээр сарын 22-ны байдлаар бэлчээрийн ургамлын үе шат явагдаж дууссан.

Мал аж ахуйд зохиогдож байгаа ажил, малын бэлчээрлэлтэнд цаг агаарын байдал хэвийн ажил саатаагүй. Бог, бод малын тарга хүч сайн, худгийн болон цасны усаар ундаалж байна. Нийт нутгийн 70 орчим хувь нь цасан бүрхүүлээр хучигдсан байна.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл (NO<sub>2</sub>), хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>2</sub>) хоногт 3 удаа, нийт 14 сорьцыг авч шинжилгээг 42 удаа хийлээ. 11 дүгээр сарын 1-20-ны өдрүүдийн дээжинд шинжилгээ хийсэн ба шинжилгээний дүнгээр дундажлахад азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.010, сарын хүлцэх агууламж нь 0.050, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.013, сарын хүлцэх агууламж 0.050 байгааг харахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

**Тээвэр, авто замын талаар:** Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 11 дүгээр сарын 20-ны байдлаар 254, өссөн дүнгээр 2967 тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

Хот хооронд 704 иргэн, сум хооронд 145 иргэн зорчиж, 66 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачаа тээвэрлэлтийн 1300 замын хуудас олгосон байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан багийн хил зааг тодорхойлох ажлын хэсгийн гишүүд 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Сүмбэр сумын 1, 2, 3, 4 дүгээр багийн Засаг дарга нар болон багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга нартай багийн хил зааг дээр очин хээрийн судалгаа хийн солбицолыг тодорхойллоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10 дугаар тогтоолоор 2019 онд газрын төлбөрийн орлого 163 811.8 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 192 сая төгрөг төвлөрүүлж 117 хувьтай байна. Үүнд:

- 45 аж, ахуйн нэгжээс –158118774.02 төгрөг
- 201 иргэдээс–23666185.98 төгрөг
- 30 төрийн байгууллагаас – 10215040 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна. Үүнд:
- 29 аж, ахуйн нэгжээс –81'735'630.3 төгрөг
- 64 иргэдээс– 6'883'691.2 төгрөг
- 16 төрийн байгууллагаас – 5'180'678.5 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 36 дугаар тушаалаар баталсан “Хот байгуулалтын кадастр” БД 14-102-19, 2019 оны 38 дугаар тушаалаар баталсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын дагуу Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг бүрдүүлснээр аймгийн нийт барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн талаарх мэдээллийг нэг дороос, нэгдсэн цогц үйлчилгээг авах боломжтой юм.

**Худалдан авах ажиллагааны талаар:** 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 69 төсөл арга, хэмжээний үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахаас 69 үнэлгээний хорооны захирамжийг гаргуулан биелэлтийг ханган ажилласан. Тендер шалгаруулалтыг зохион байгуулсан 69, гүйцэтгэл 100 хувьтай байна.

Тайлант сард давхардсан тоогоор 98 тендерийн урилгыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.govisumber.gov.mn](http://www.govisumber.gov.mn) сайтад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд оруулсан. Зарласан тендерүүдийг дараах байдлаар зарласан байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 5, Авто замын сангийн хөрөнгөөр 1, нийт 48 ажлыг цахим системээр зарлаж ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Сумдын худалдан авах ажиллагааны хүрээнд Сүмбэр сум 8, Шивээговь сум 15 ажлыг тус тус зарлаж, ажлын гүйцэтгэл 100 хувь, Баянтал сумын хувьд 11 ажил зарлахаас 7 ажлыг зарлаж, 3 ажлыг зарлахаар төлөвлөж байна харин 1 ажлын төсөв хүрэлцэхгүй байгаа тул ирэх онд шилжүүлэхээр болсон байна. Ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

**Орон нутгийн өмчийн талаар:** Улсын төсөв болон аймаг, сумдын 2019 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэж улсын комисс хүлээн авсан хөрөнгө оруулалтын ажлуудыг бүртгэлжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- ✓ Аймгийн 2018 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан 3 ажил;
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 23 ажлаас улсын комисс хүлээн авсан 2 ажил;
- ✓ Аймгийн 2019 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 24 бараа, ажил, үйлчилгээнээс 9 ажил;
- ✓ Сүмбэр сумын 2019 оны ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 8 бараа, ажил, үйлчилгээнээс 5 ажил;
- ✓ Шивээговь сумын 2019 оны ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 15 бараа, ажил, үйлчилгээнээс 15 ажил;

Орон нутгийн өмчит байгууллагуудын “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэхэд 43 байгууллагаас 40 байгууллага дүгнэгдсэн. Үнэлгээнд хамрагдаагүй Орон нутгийн өмчийн газар, Байгал орчин, аялал, жуулчлалын газар 2018 оны жилийн эцэст төрийн өмчөөс шилжиж ирсэн тул өмч эзэмшүүлэх гэрээг 2019 онд байгуулсан.

6 дугаар цэцэрлэг 2018 онд байгуулагдсан тул “Өмч эзэмшүүлэх гэрээ” 2019 онд гэрээ байгуулсан, эдгээр байгууллагууд 2020 онд дүгнэгдэнэ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас томилогдсон ажлын хэсэг манай аймагт 2019 оны 11 дүгээр сарын 8,9-ний өдрүүдэд ирж “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх ажлыг хамтран зохион байгуулан ажилласан.

2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын гүйцэтгэлийг дүгнэхэд 52,0 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрөхөөс 44.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 85 хувийн биелэлттэй байна.

## **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

### **Баянтал сум:**

Сумын бэлчээр хамгаалах ажлын хэсэг 2019 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд хөдөөгийн багуудаар ажиллаж бусад аймаг, сумдаас ирсэн отрын малчдаар орж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Бэлчээр ашиглах журам”-ыг танилцуулж, зөвшөөрөлгүй буусан айлуудад нүүх тухай шаардлага хүргүүлж, малын вакцинд хамрагдах, малын хулгай, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг өгч ажиллалаа.

Сумын Соёлын төвийн уран бүтээлчид аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхэд багачуудад “Өнчин цагаан ботго” хүүхэлдэйн жүжиг тоглосон.

Монголын үндэсний уламжлалт тоглоом наадгайг хүүхэд багачуудад өвлүүлэн уламжлуулах түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Монгол наадгай” уралдааныг зохион байгуулж, 9 багийн 60 хүүхэд авьяас билэг, чадвараа дайчлан оролцлоо.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 30000 толгой мал хамруулахаас 55 өрхийн 28300 толгой мал хамруулж, гүйцэтгэ 94,3 хувьтай, шүлхийн вакцинд 3200 толгой үхэр хамруулахаас 40 өрхийн 1565 толгой хамруулж, гүйцэтгэл 48,9 хувьтай байна.

### **Сүмбэр сум:**

11 дүгээр сарын 08-ны өдөр сумын Засаг даргын орлогч 5, 6 дугаар багийн Засаг дарга нар аймгийн малчдаар орж өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж, үлийн цагаан огтоны танадалт судалгаа хийлээ. Сумын хэмжээнд одоогийн байдлаар гадны аймаг, суманд отор нүүдэл хийж байгаа 31 малчин өрхийн 17313 толгой мал байна.

Төрийн албан хаагчдын нөхөрсөг спортын тэмцээнийг зохион байгуулж 14 байгууллагын 350 гаруй албан хаагчийг хамруулсан.

6 сартайгаас 5 хүртэлх насны 368 хүүхдийг витаминжуулж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Золбин нохой, муур устгалын ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд хувиараа хөдөлмөр эрхлэгчтэй хамтран төвийн 3 баг болон хөдөөгийн 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт хийж, нийт 110 нохой устгасан.

2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Намрын эргүүл шалгалтын ажлын хувиарын дагуу 5, 6 дугаар багийн нутаг дэвсгэр Улаан Цагаан ус, Тагт, Сансар уул, Шар бүрд, Жаргалант, Хээнций, Цайдам, Чойрын Богд уул, Уул худаг, Цагаан тэмээт, Холбоо, Баянбулаг гэсэн маршрутаар эргүүл шалгалтыг зохион байгууллаа. Эргүүл шалгалтын үеэр зөрчил илрээгүй ба малчдад хууль бус ан, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хүргэн, гарын авлага тараасан.

#### **Шивээговь сум:**

Сумын Засаг даргын 2019 оны А/23, А/24 дүгээр захирамжаар багуудын тооллогын түр товчоог байгуулан Хүн ам орон сууцны 2020 оны завсарын тооллогын ажлыг зохион байгуулж, 380 сууц тоологдохоос 398 сууц тоолж төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Үүнд: Тоологдсон 398 сууцаас 134 буюу 33,7 хувь нь сууцны тусдаа байшин, 2 буюу 0,5 хувь нь биеэ даасан тохилог сууц, 48 буюу 12,1 хувь нь сууцны бус зориулалттай, 210 буюу 52,8 хувь нь гэр сууцыг тус тус тоолсон байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 10 дугаар сарын 31-ний байдлаар 47347300 төгрөг төвлөрүүлэхээс 42107900 төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөө 89 хувийн биелэлттэй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар 40 иргэнд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

“Малчдын нэг өдөр” өдөрлөгийг 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Өдөрлөгөөр малчдын дунд гар бөмбөг, хөгжөөнт буухиа, АХА зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн угийн бичгийн сургалт хийсэн. Уг арга хэмжээнд 36 малчин өрх хамрагдсан.

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахаар 95 ажил төлөвлөснөөс 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 87 ажил бүрэн хийгдэж төлөвлөгөө 91,6 хувийн хэрэгжилттэй байна.

Сумын Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/158 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг бог малын Мязан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн зохион байгуулж 61 өрхийн 14476 толгой хурга, ишигийг тарилгад хамруулж дархлаажуулалт 77 хувьтай байна. Мөн шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 45 өрхийн 1786 үхрийг хамруулсан байна.

Сумын хэмжээнд Дундговь аймгийн Луус сумын 1 малчин, Сайнцагаан сумын 1 малчин нийт 1100 бог малтай өвөлжихөөр төлөвлөж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/342 дугаар “Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” захирамж, сумын Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/165 дугаар захирамжын дагуу Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн 5 хоногийн хугацаанд энгийн механик, биологийн аргаар 3 цэгт 2000 га газар буюу нутгийн урд, баруун урд, баруун хойд талыг хамруулан зохион байгуулж байна.

Байгаль орчны сайдын 2008 оны 269 дүгээр тушаалаар батлагдсан “Усны тоо бүртгэл явуулах журам”-ын дагуу “Уст цэгийн тооллого”-ын ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулж, бэлчээрийн зориулалттай 60 худаг, төв суурингийн 7 худаг, 8 булаг, Шивээ овоо хувьцаат компанийн 46 худаг, Страто нүүрс угаах үйлдвэрийн 2 худаг тоологдсон байна.

Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран 2019 оны 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд батлагдсан хуваарь маршрутын дагуу хууль бус ан агнуур, хээрийн түймэр малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Шивээговь сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 43 малчин өрхийн 90 гаруй иргэнд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хууль, хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, сурталчилгаа гарын авлага тарааж ажилласан.